



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН  
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2023 оны 03 сарын 31 өдөр

Дугаар А/130

Улаанбаатар хот

Удирдах зөвлөл дэх багш нарын  
төлөөллийн сонгуулийн удирдамж батлах,  
сонгууль зохион байгуулах тухай

Боловсролын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1, 36.3 дахь хэсэг, МУИС-ийн дүрмийн 4.1.2, 4.3.1 дэх заалт, Удирдах зөвлөлийн дүрмийн 2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “МУИС-ийн Удирдах зөвлөл дэх багшийн нэг (1) төлөөллийг сонгох удирдамж”-ийг 1 дүгээр хавсралтаар, сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. МУИС-ийн Удирдах зөвлөл дэх багшийн төлөөллийг сонгох ээлжит сонгуулийн нэгдүгээр үе шатыг 2023 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр бүрэлдэхүүн/салбар сургууль тус бүрт, хоёрдугаар үе шатыг 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр МУИС-ийн хэмжээнд зохион байгуулахаар тов тогтоосугай.

3. Биеийн тамирын тэнхимийн багш нэгдүгээр үе шатны сонгуульд Бизнесийн сургуулийн багш нарын хуралд оролцон нэр дэвших болон санал өгөх эрхтэйгээр оролцуулсугай.

4. Удирдах зөвлөл дэх багшийн төлөөллийг сонгох удирдамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг МУИС-ийн удирдах зөвлөлд багшийн төлөөллийг сонгох ажлын хэсгийн ахлагч (Н.Баатарбилэг)-д даалгасугай.


ЗАХИРАЛ



Д.БАДАРЧ

1423061296





## **МУИС-ИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛ ДЭХ БАГШИЙН ТӨЛӨӨЛЛИЙГ СОНГОХ УДИРДАМЖ**

### **Нэг. Сонгуулийн үе шат**

- 1.1. Удирдах зөвлөл дэх багшийн төлөөллийн сонгуулийг хоёр үе шаттайгаар зохион байгуулна.
- 1.2. Нэгдүгээр үе шатны сонгуулийг 2023 оны 4 дүгээр сарын 06-ны өдөр ажлын цагт багтаан бүрэлдэхүүн/салбар сургууль тус бүр зохион байгуулна. Бүрэлдэхүүн/салбар сургуулиуд хоёрдугаар шатны сонгуульд нэр дэвшүүлэх нэг /1/ багшийн нэр, хамт олны хурлын тогтоол, сонгуулийн үр дүнг МУИС-ийн нийт үндсэн багш нарын санал хураалтыг зохион байгуулах ажлын хэсэгт ирүүлнэ.
- 1.3. Хоёрдугаар үе шатны сонгуулийг 2023 оны 4 дүгээр сарын 14-ны дотор зохион байгуулж сонгуулийн дүнг тогтоол хэлбэрээр гарган МУИС-ийн захиралд уламжилна.

### **Хоёр. Нэр дэвшигчид тавигдах шаардлага**

- 2.1. МУИС-ийн үндсэн орон тооны багш байх (МУИС-ийн профессор багш ажиллуулах журам 9.4, Удирдах зөвлөлийн дүрэм 2.4-т заасан). Үндсэн орон тооны багш гэдэгт МУИС-д профессор, дэд профессор, ахлах багш, багш, дадлагажигч багшийн зэрэглэлд ажиллаж буйг ойлгоно. Дээрх нөхцөлд МУИС-д зөвлөх профессор, зөвлөх дэд профессороор ажиллаж буй багшийг үл хамааруулна (МУИС-ийн профессор багш ажиллуулах журам 9.4, Удирдах зөвлөлийн дүрэм 2.4, МУИС-ийн дүрмийн 4.4.1.2-т заасны дагуу).
- 2.2. МУИС-д 5-аас доошгүй жил ажилласан байх.
- 2.3. Ашиг сонирхлын зөрчилгүй байх (Удирдах зөвлөлийн дүрэм 3.2-т, МУИС-ийн дүрмийн 4.1.4 болон 4.3.7-д заасны дагуу МУИС-ийн Захиргааны зөвлөлийн гишүүн нэр дэвшихгүй).

### **Гурав. Санал өгөх эрх**

- 3.1. МУИС-ийн үндсэн орон тооны багш байна. Санал өгөх эрх бүхий Үндсэн орон тооны багшийг энэхүү удирдамжийн 2.1-т зааснаар ойлгоно.
- 3.2. Багш саналаа сонгууль явуулахаар урьдчилан тогтоосон цаг, газарт холбогдох баримт бичгийн хамт биечлэн очиж өгнө.

### **Дөрөв. Бүрэлдэхүүн/салбар сургуулиас нэр дэвшигчийг сонгох хурлын зохион байгуулалт**

- 4.1. Бүрэлдэхүүн/салбар сургуулийн удирдлага МУИС-ийн удирдах зөвлөл дэх багшийн төлөөлөлд нэр дэвшигчийг сонгох хурлыг зохион байгуулна.
- 4.2. Хурал үндсэн багш нарын 50-иас доошгүй хувь нь ирж оролцоноор хүчин төгөлдөрт тооцогдоно.
- 4.3. Хуралд оролцогчдоос 3-5 багшийн бүрэлдэхүүнтэй комиссыг сонгож хурлыг удирдуулна. Бүрэлдэхүүн/салбар сургуулийн захирлын туслах хурлын тэмдэглэл/аудио бичлэгийн хамт/хөтөлнө.
- 4.4. Удирдах зөвлөл дэх багшийн төлөөлөлд нэр дэвшигчийг сонгох хуралд үндсэн орон тооны багш нээлттэйгээр нэр дэвших болон дэвшүүлэх эрхтэй байна.
- 4.5. Хуралд оролцогчдын саналаар 3 эсхүл 5 багшийн төлөөлөл бүхий тооллогын комиссыг сонгож байгуулна. Тооллогын комисс саналын хуудсыг бэлтгэнэ.



- 4.6. Багш нууцаар санал өгөх эрхийн үндсэн дээр тухайн бүрэлдэхүүн/салбар сургуулиас нэг /1/ нэр дэвшигчийн төлөө саналаа өгнө.
- 4.7. Нууц санал хураалтыг зохион байгуулах тооллогын комисс нэр дэвшигчдийг цагаан толгойн үсгийн дарааллаар байршуулсан нэр бүхий саналын хуудсаар зохион байгуулж, дүнгийн талаар тогтоол гаргана.
- 4.8. Санал хураалтын дүнгээр хамгийн олон санал авсан багшийг дараагийн (хоёрдугаар) үе шатны сонгуульд оруулах тухай хамт олны хурлын шийдвэрийг гаргана.
- 4.9. Хэрэв нэр дэвшигчдийн санал тэнцвэл тухайн санал тэнцсэн нэр дэвшигчдийг дахин санал хураалтад оруулан хамгийн олон санал авсан нэр дэвшигчийг сонгогдсонд тооцно.
- 4.10. Бүрэлдэхүүн/салбар сургуулийн хурлаас хоёрдугаар үе шатны сонгуульд ажиглагчаар оролцох 1 багшийг сонгон энэ тухай тэмдэглэлд тусган МУИС-ийн нийт үндсэн багш нарын санал хураалтыг зохион байгуулах ажлын хэсэгт уламжилна.
- 4.13. Хурлын тэмдэглэл, тооллогын комиссын тогтоол, хамт олны хурлын шийдвэр, багш нарын ирцийн бүртгэлийг МУИС-ийн нийт үндсэн багш нарын санал хураалтыг зохион байгуулах ажлын хэсэгт 2023 оны 4 дүгээр сарын 07-ны дотор ирүүлнэ.

**Тав. МУИС-ийн Удирдах Зөвлөл дэх багшийн төлөөллийг сонгох сонгуулийн зохион байгуулалт**

- 5.1. МУИС-ийн захирлын тушаалаар байгуулагдсан МУИС-ийн үндсэн багш нарын санал хураалтыг зохион байгуулах ажлын хэсэг хоёрдугаар үе шатны сонгуулийг удирдан зохион байгуулна.
- 5.2. Хоёрдугаар үе шатны сонгууль зарлагдсан өдрийн 8 цаг 00 минутаас 16 цаг 00 минутын хугацаанд МУИС-ийн хичээлийн 1 дүгээр байрны 320 тоот өрөөнд явагдана.
- 5.3. Сонгууль МУИС-ийн үндсэн орон тооны нийт багш нарын 50-иас доошгүй хувь оролцож санал өгсөнөөр хүчинтэйд тооцогдоно.
- 5.5. Ажлын хэсэг хоёрдугаар үе шатны санал хураалтад оролцон санал өгөх эрх бүхий багш нарын нэрийн жагсаалтыг гаргана.
- 5.6. Ажлын хэсэг бүрэлдэхүүн/салбар сургуулиудаас сонгогдсон багш нарын товч танилцуулгыг нэг загварын дагуу бэлтгэж, МУИС-ийн цахим хуудаст санал хураалт болохоос 3-аас доошгүй хоногийн өмнө байршуулна.
- 5.7. Багш саналын хуудаст холбогдох зааврын дагуу саналаа өгнө. Саналын хуудас зөвхөн нэг /1/ нэр дэвшигчид санал өгснөөр хүчин төгөлдөр байна. Бусад хэлбэрээр өгсөн аливаа саналын хуудсыг хүчингүйд тооцно.
- 5.9. Багш нарын нууц санал хураалтаар хамгийн олон санал авсан эхний нэг /1/ нэр дэвшигчийг МУИС-ийн Удирдах Зөвлөл дэх багшийн төлөөлөлд сонгогдсонд тооцно.
- 5.10. Хэрэв нэр дэвшигчдийн санал тэнцвэл тухайн санал тэнцсэн нэр дэвшигчдийг дахин санал хураалтад оруулан хамгийн олон санал авсан нэр дэвшигчийг сонгогдсонд тооцно.
- 5.11. Ажлын хэсэг санал хураалтыг 16 цаг 00 минутад хааж тухайн өдөрт багтаан саналыг тоолж сонгуулийн дүнг тогтоол хэлбэрээр гарган энэ тухай МУИС-ийн захиралд уламжлана.
- 5.14. Саналын хайрцагийг битүүмжлэн санал авч эхлэх болон санал хураалтыг хааж тоолж эхлэх үйл ажиллагаанд бүрэлдэхүүн/салбар сургуулиас сонгогдсон ажиглагчийн төлөөллийг заавал байлцуулна.
- 5.15. Ажлын хэсэг санал хураалтын дүн, холбогдох материалуудыг нэгтгэн, архивд шилжүүлнэ.